



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/333


Номгон

Усалгааны системийг шийдвэрлэхэд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Д.Дэлгэрмаагийн санаачилгаар Оготонотой булаг дээр "Ногоон төгөл" аян зохион байгуулагдсантай холбогдуулан усалгааны системийг шийдвэрлэхэд зарцуулагдах 5.000.000 (Таван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

621010847